

**ЛАОЗАР ХУУРЧИЙН ХЭЛСЭН “ЧЭН ЯО ЗИНИЙН ЭМЧИЛСЭН НЬ” ГЭДЭГ
ХУУРЫН ҮЛГЭР ДЭХЬ ЧЭН ЯО ЗИНИЙ ДҮР**

Цогт*

Агуулгын товч: Тус өгүүлэлд Лаозар хуурчийн хэлсэн “Чэн Яо Зинь эмчилсэн нь” гэдэг хуурын үлгэр дэх Чэн Яо Зиний дүрийг таван талаар задлан шинжилж хуурчаас хятад зохиол ба өнгөрсөн хуурчийн уламжлалын суурин дээр монгол түмэнд таашаагдсан монголжуу Чэн Яо Зиний дүрийг урлан бүтээжээ гэж үзсэн байна.

“Чэн Яо Зинь эмчилсэн нь” гэдэг үлгэрийг хуурч Лаозар 1973 онд Шилийн гол аймгийн Сөнд баруун хошуунд үлгэр холбоо хэлж явахдаа Өвөр монголын радио хороонд тусгай хуурч байсан Дорж хуурчаас анх удаа сонсчээ. Тухайн үед хуучны уламжлалт хуурын үлгэрийг хэлүүлэхгүй байж, зөвхөн хувьсгалт үлгэр дууриал ший-г л дуулуулж байжээ. Лаозарын хэлэхээр тус үлгэрийг Дорж хуурч өөрийнх нь багш Пажай хуурчаас сонссон гэнэ. Пажай нар иймэрхүү үлгэрийг олон зохиож хэллээ гэдэг. Зарим хуурч тус үлгэрийг “Шан ма зуань” үлгэрээс авлаа гэдэг боловч түүнд ийм үлгэр байхгүй. Хуурч нарын хэлдэг “Шан ма зуаний” үлгэр гэдэг нь хятад үндэстэний “Шян ма зуаны үлгэр”-ийг хэлж байгаа юм. Монголчууд Шян гэдэг хятад үгийг “Шан” гэж монгол хэл аялгуунд ойртуулан авсан нь илхэн. Бид тус үлгэрийг үнэхээр хятадын “Шян ма зуаний” үлгэрээс авсан болов уу хэмээн Шян ма зуаний үлгэрийг хичнээн уншин шүүсэн боловч түүнд тус үлгэр байсангүй. Харин Чэн Яо Зиний бусад үлгэр нилээд олон байлаа. Бид бас “Сүй улс Тан улсын үлгэр”, “Тан улсын үлгэр” зэрэг хятадын үлгэрүүдийг оруулж тус үлгэрийг хичнээн эрж үзсэн боловч бүр олдсонгүй.

Иймээс бид тус үлгэрийг хуурч нар өөрсдөө зохиосон болов уу хэмээн таамаглаж байна. Тус үлгэрийг хятадын “Шян ма зуаний” үлгэрээс авлаа гэдэг нь хүмүүсийн итгүүлэх хүчийг нэмэгдүүлэхийн төлөө юм. “Шян ма зуань” (Шэн ма зуаний) үлгэр бол Бэнсний үлгэр болно. Бэнсний үлгэрийг хөдөө нутгийн бичиг соёлгүй хүмүүс үсэг бичгээр уламжлагдан ирсэн тул үнэн түүхийн үлгэр хэмээн итгэдэг байжээ. Тэгвэл Шян ма зуаний үлгэрт Чэн Яо Зиний үлгэр нилээд олон орсноос хуурч нар тус үлгэрээ зохион хэлээд хүмүүсийг нэн их итгүүлэхийн төлөө Шян ма зуаний үлгэрээс авлаа гэж хэлэх болжээ. Хуурч Лаозар “Чэн Яо Зинь эмчилсэн нь” гэх үлгэртээ Чэн Яо Зиний дүрийг амьдлаг сайхан бүтээжээ. Тэр Пажай зэрэг дархан хуурч Дорж зэрэг алдарт хуурчийн бүтээсэн Чэн Яо Зиний уран дүрийг улам нэг алхам зан чанаржуулж, хятад үндэстний “Тан улсын үлгэр”, “Шян ма зуаний үлгэр” дахь “соёлгүй бичиг мэдэхгүй боловч сэцэн сэргэлэн, зэвсгийн эрдэмд сайнгүй боловч үнэн ёсны төлөө эрэлхгээр тэмцдэг, төрсөн байдал муухай боловч шог хошиндуу, цагаавар сэтгэлтэй, чин үнэнч, цөс зоригтой, эрс тасархай, эрхэм зэрэг эд ашигт дургүй, алсын

* Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн профессор

харалттай” дүрээс нэлээд өөр, монгол түмэнд таашаагдсан монголжуу Чэн Яо Зиний уран дүрийг урлагжуулан амилуулав. Чэн Яо Зиний зан чанарт хэдийгээр хятадын уран зохиол дахь Чэн Яо Зиний зан чанарын үлдэгдэл оршсоор боловч энэхүү зан чанар нь нэгдэн гол бус болжээ.

Хуурын үлгэрийн урлагийг судлахад хүний дүрээс салж эс чадна. Хуурч нар хүмүүсийн зүрх сэтгэлд хоногшсон дүрийг босгохын төлөө зүрхэн тамираа шавхаж байдаг. Алдарт хуурч Лаозар ч “Чэн Яо Зинь эмчилсэн нь” гэдэг үлгэртээ хамгийн гол дүр болох Чэн Яо Зиний дүрийг босгохын төлөө оюун ухаанаа шавхаж хүчин чадлаа гаргаж амжилт ололт олжээ. Өөрөөр хэлбэл хуурч Лаозар Чэн Яо Зиний дүрийг хүмүүсийн зүрх сэтгэлд хоногштол сийлбэрлэж гаргажээ. Бүгд олныг мэдэгжээр хүний дүрийг голдуу түүний зан чанараар нь гаргадаг. Хуурч Лаозар бол утга урлагийн онолын төвшин нилээд өндөр оюутан хуурч юм. Тэр хуурын үлгэрт уран дүрийг хэрхэн амилуулах тухай өөрийн онол үзэлтэй байж, түүгээрээ уран дүрийг босгох үйлдлэгээ жолоодуулж байдаг. Түүний онол үзэлд нь “үлгэр холбооны конспект”¹, “Зарад хуурчдын судлал”² зэрэг судлал шинжлэлийн бүтээл туурвил нь бичигдэн оржээ. Жишээлбэл: хуурын үлгэр дэх дүрийн тухай: “Үлгэр (хуурын үлгэрийг хэлж буй зохиогч) хэлэхэд дүр бүтээхээр голдлого болгох юм. Үлгэрийн хүн (хуурын үлгэр дэх уран дүр)-ий юу хийсэнд байх биш яаж гэж хийсэнд нь байх юм. Яаж хийснийг нь амьдлаг дүрслэг сайхан илтгээд гаргавал даруй үлгэрийн хүн аяндаа босоод ирэх юм”³ гэж ярьсан мөртөө хуурын үлгэр дэх дүрийг хэрхэн бүтээх аргыг зургаан төрөлд ангилан өгүүлжээ. Иймэрхүү онол үзэлтэй оюутан хуурч болсноос түүний хэлсэн үлгэр дэх Чэн Яо Зиний дүр нь мах цустай, өвөрмөц зан чанартай гоё дүр болж чаджээ. Доор бид Чэн Яо Зиний дүрийг хэрхэн бүтээсэн тухай задалж үзье.

Нэг. Архинд дуртай зан чанар: Чэн Яо Зиний хамгаас товойсон зан чанар гэвэл архи гэвэл амиа авахгүй дуртай зан чанар болно. Энэхүү зан чанарыг хуурчаас олон арга замаар урлаг сайхан илрүүлэн гаргаж хүмүүсийн сэтгэлд хоногшуулжээ.

Хуурчаас үлгэрээ эхлүүлээд:

“Хүчтэй хүн нь хаан суувал
Хүчирхэг улсыг сайшаагаад
Бодлоготой хүн нь хаан суувал
Бодлоготой улсаа магтдаг байжээ
Бутантай архиндаа дуртай нь
Чэн Яо Зинь хаан юм түлд
Бүгд бүгдээрээ хурим найр хийгээд
Өдөр бүр найрлан суув”

гэж өдөр өдөр баяр найр хийгээд архины үнэр гэрээс тасрахгүй, хундага жүнзийн дуу чихнээс холдохгүй болсон наргиант байдлыг үзүүлж Чэн Яо Зиний архинд дуртай зан чанарыг анх удаа илрүүлжээ. Энэ нь даруй хуурчийн хэлдэг “Хажуу талаас танилцуулах арга”⁴ юм. Түүний дараа нь цэргийн Зиюүн ши, Сюй Мао Гүн, Чэн Яо

¹ Лаозар (2007 оны 4 сар) “Үлгэр холбоон конспект” Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.,

² Луузар (2009 оны 1 сар) “Зарт хуурчдын судлал” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.,

³ Лаозар (2007) “Үлгэр холбоон конспект”, Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.,

⁴ Лаозар (2007) “Үлгэр холбоон конспект”, Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.,

Зинийг арван таван өдөр архи уувал арван зургадугаар өдрөөс нь эхлээд архиа тас зогсох хэрэгтэй гэж шаардан хэлдэг. Үүнд Чэн Яо Зинь : “Болохгүй, арван тавхан өдөр архи уугаад ямар явдал буй? Ширээн эзэн чинь дээр нь, шинж үгүйгээсээ алдар, гуравхан өдөр нэмье, арван найман өдөр болно уу? үгүй юу? гэж илүү гурван өдөр гуйж олсноор дүрсэлдэг. Энэ нь даруй хуурчийн хэлдэг “Үг яриагаар дүрслэх”⁵ арга нь мөн буюу. Чэн Яо Зинь арван наймдугаар өдрөө өнгөрөөд арван есдүгээр өдрөө дахин мөн архиа санаж гачигдаж байгаа байдлыг түүний сэтгэлийн хөдөлгөөнөөр нь:

*“Багын нутаг Бань жао даяньдаа
Дуугуй явсан ч больё доо
Балай /хагас/ жингээр архи уухад
Асуух хүн гэж байна уу даа
Бат журмын Эр Лүн Шаньд
Дуугуй хаан гэж суусан чинь
Бан /хагас/ жүнз архи бас үгүй одоо
Балархад тулаад ирлээ шүү дээ
Албан төрийн газар
Эрхийг нь авч суучихаад
Амандаа орох архигүй
Хатаж үхэх л зовлон байна
Аавын нутаг Бань жао даяньдаа
Аруншаа хойшоо эргэчихээд
Аргалаа түүгээд худалдах лай
Архины зоосонд дутна уу даа?”*

гэж дүрслэв. Архигүй балрахад тулсан Чэн Яо Зинь энэ мэт сэтгэлийн угаасаа архигүй зовсноос өндөр уул Эр Лүн Шань-аас тэр шөнөдөө салж төрсөн нутаг руугаа явсан байна. Энэ нь даруй оюутан хуурч Лаозарын хэлдэг “Сэтгэлийн хөдөлгөөнийг нь дүрслэх”⁶ арга юм.

Чэн Яо Зиний архиа санасан Лаозар хуурчийн багшийн багш Пажай хуурч ч холбон дуулж байсан юм. Пажэй гуайгаас:

*“Үүл нь татаад тунаран суугаад
Үргэлж жавар жихүүнээд гарав
Өврөөр одож энгэрийг даваад
Өвчүү цээжинд мөлийгөөдөхлөө
Элэг нь жингэнээд сэтгэл хөдлөхөд
Элэн сэлэн “Эл лиян Сэ лиян” архи нь бодогдлоо.
Цагаан хөх үүл хэсэг
Чанар татаад сансарт мөргөөд
Сэрчигнэж ирэх сэрүүн жавар ээ хө
Цээжээр утгаад сугыг нь нэвтлээд
Сэтгэлийн дотор сархад санагдаад”⁷*

⁵ Лаозар (2007) “Үлгэр холбоон конспект”, Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.,

⁶ Лаозар (2007) “Үлгэр холбоон конспект”, Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.,

⁷ Цогт, Чэн Ган Лүн (2002) “Пажайн судлал”, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.,

гэж архиа санасан Чэн Яо Зинийг уяруун хөг аялгуугаар уянгалан дуулжээ. Үүнээс бид Чэн Яо Зиний архиа санасан дотоод сэтгэлгээг илтгэсэн Лаозар хуурчийн арга барил нь хуурч Пажайнхтай улбаа нэгтэй гэдгийг мэдэж болно. Чэн Яо Зиний архиа энсэртэл санаж байхыг түүний үйл хөдөлгөөнөөр ч дүрсэлсэн юм. Түүнд, Чэн Яо Зинийг “Уйлан уйлан алджээ, үнэхээр хүнгүй болбол уйлчихъя гээд босоод өндийгөөд үзэхүлээр(үзэхлээр) үүд рүү ирж байх хүн гэж үгүй, булан өвдөө хараад бугштал уйлсаар тэр шөнийн харанхуй болчихов” гэж халуун архиа санаад бугштал уйлж байгаагаар дүрсэлжээ. Энэ нь даруй хуурчын онолжуулан ярьдаг “үйл ажиллагаагаар нь дүрслэх”⁸ арга мөн. Хуурч залгаад Чэн Яо Зиний сэтгэлийн хөдөлгөөнийг нь:

“Булбарайхан насны

Охин цагаан сүүнээсээ

Бойжоод өөлэй болохын үедээ

Зогсоно гэвэл зогсож болно

Бүгд биеийг бүлээсгээд өгдөг

Бэлэн сайхан архинаас

Биеэрээ одоо сална гэдэг чинь

Бэлэвсэрч үхэж байх зовлон шүү” гэж гүн хайр сэтгэлтэйгээр холбон дуулж ёгтлон уянгалуулав.

Дээрхээс бид Лаозар хуурч Чэн Яо Зиний архинд дуртай зан чанарыг гаргахын төлөө хэдэн зүйлийн аргыг хэрэглэдэг мөртөө заримдаа хоёр, гурван зүйлийн дүрслэх аргыг угсруулан хэрэглэдэг гэдгийг мэдэж болно. Харамсалтай нь Лаозар гуай хэдэн зүйлийн аргыг угсруулан хэрэглэдэг аргаа онолын номондоо хураангуйлан оруулсангүй орхижээ. Хуурчаас Чэн Яо Зиний архинд дуртай зан чанарыг энд хүртэл зураглаад зогссон биш, цаашид бас архиа санаад уулнаас буусан, уулнаас буугаад архиа санасан, архиа санаад Шао Гуо эрсэн, Шао Гуа-д ороод архи уусан зэрэг үйл явдлыг ч нэгд нэгээр дүрслэн зураглажээ. Жишээлбэл Чэн Яо Зиний долоон тогооны ганг доор нь тосгуур болгож тосоод цоргоос шуугитал халуун архи бууж байхыг үзээд “энэ сая одоо гайхамшигтай, энэ сайхан аа” гэж гайхан баярласан сэтгэлгээ, хариулж нэрж байх Эл Гуо Тоу архийг долоон хул уугаад дугтарч байгаад бас нэг хул тусгасан байдал зэргийг маш нарийн дүрсэлжээ. Залгаад Чэн Яо Зинь архинд согтсон байдлыг:

“Архиных нь халуун

Дотогшоо болоод ирлээ

Амных нь халуун

Гадагшаа гараад ирлээ”

гэж толгой холбож сүүл даршуулан дуулаад морь довтолгон яваа дүр байдлыг:

“Тэр айлаас холдоод

Гараад явснаа мэдэхгүй

Тэртээ уулыг даваад

Ороод явсанаа мэдэхгүй

Нөгөө жалгын дундуур

Гүйлгэж байхаа мэдэхгүй

Нэг ч мэдэхгүй газар

Очиж байхаа мэдэхгүй ...

⁸ Лаозар (2007) “Үлгэр холбоон конспект”, Өвөр Монголын багачууд хүүхдийн хэвлэлийн хороо.,

Элэг зүрх юутай
Гараад ирмээр боллоо
Эрүү амтай юутай
Салаад явмаар боллоо
Энэ аймар нүд
Бутарч гармаар боллоо
Эгэс салсан ухаан санаа
Бутарч явмаар болж”

гэж холбон дуулж дүрслэн зураглажээ. Хамаг сүүлд нь Чэн Яо Зинь нэг уулын хярын сагсгар модны сүүдэрт ирж мориноосоо бууж нүцгэлэн унтдаг. Түүний унтаж байгаа байдлыг “хамар нь дооошоо хувар хувар хийж шороог нүл хийдгээд тэр доор л одоо нэг тоос бударгаад л болохгүй болчихлоо” гэж мэдээ сэхээгүй унтаж орхисноор дүрсэлдэг.

Дээрх ярьсанаас үзвэл, хуурч Лаозар өнгөрсөний уламжлалын суурин дээр Чэн Яо Зиний архинд дуртай зан чанарыг олон талаас, олон арга барилаар дүрслэн зураглаж, шинэ амжилт бүтээлтэд хүргэсэн байна. Энэхүү ам Чэн Яо Зинь амжилтад хүрч чадсан нь түүний онол ба үйлдэлгээг уялдуулж, онолоор үйлдлэгээг жолоодуулсантай нь холбоотой юм.

Хоёр. Өнгөнд дуртай зан чанар: Чэн Яо Зиний өнгөнд дуртай зан чанарыг дархан хуурч Пажайгаас:

“Астаан юманд дургүй
Архинд бол дуртай
Өнгөнд бас бахтай
Энэ Яо Зиний байдал аа”⁹

гэж дүгнэн хураангуйлсан юм. Лаозар хуурч ч “Чэн Яо Зинь эмчилсэн нь” гэх хуурын үлгэртээ Чэн Яо Зиний өнгөнд дуртай зан чанарыг товойлгон илрүүлсэн юм. Чэн Яо Зинь, Лю Зя Зуан-д нүгэл ёрыг арилгаад алдар нэр мандахын үед, Дэн Жоу Фү-ийн Ян Линь Ван өөрийн гүнжийнхээ өвчнийг үзүүлэхээр Лу минь, Сян Юй Минийг томилж Чэн Яо Зинийг залахаар илгээдэг. Лу Мин, Сян Минь хичнээн залан гуйсанч Чэн Яо Зинь очихгүй, гүнжийн өвчнийг засахгүй гэжээ. Хамгийн сүүлд нь тэр хоёр аргаа барахдаа:

“Алдар гарсан Зю Мин Сянь Шэн
Биеэрээ хүрээд очвол оо
Албаны дээд Ян Линь Ван Е
Гүнжээ чамд шагнана гэнэ шүү”

гэжээ. Түүнийг сонссон Чэн Яо Зинийг хуурчаас:

“Түмэн лангийн ашиг гэлээ
Түүнийг одоо дурлахгүй
Төрийн дээд ван сууж байсан
Яо Зинь түүнээр дутна уу?
Төлөвтэй сайхан гүнж гэлээ
Түүштэй эрүүтэйгээ таталцлаа
Дэн Жоу Фү ма гэлээ
Дээлийн хормой нь дэрвэлзэнэ ...
Алт мөнгө зоос гэвэл

⁹ Цогт, Чэн Ган Лүн (2002) “Пажайн судлал” Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.,

Аглагийн ууландаа барзай уу даа
Алдар их Хунь Ши Муо Ван
Тэр явдалд бас гар хөдлөхгүй
Аху ч Вангийн гүнжэ гэлээ
Арааны шүлс нь ус гарчихлаа
Авбал аваад олбоос олоод

Аймаар аймаар санагдлаа” гэж адилтган зүйрлэх аргаар алт мөнгө, ашиг зоосонд дургүй, өнгөд ховдог зан чанарыг “арааны шүлс нь гарсан” гэж дүрслэн зураглажээ. Ян линь Вангийн гүнжийн өвчнийг засахаар ирсэн Чэн Яо Зинь гүнжийг үзсэн байдлыг:

“Төрснийх нь биш боловч
Зурсаных нь болоод
Хөмсөгнийх нь төлөв нь
Хэцүү сайхан харагдаад
Нүднийх нь байдал
Хөнгөмсөг чинээ үзэгдээд...”

гэж дүрсэлжээ. Хуурч нар Сяо Зиэ- г магтахдаа үргэлж:

“Намрын цагийн эрвээхэй
Навч уу цэцэг үү эргэлдмээр
Найман настай хүүхдүүд
Найнаагаа хаяад гүйчихмээр
Ная гарсан настайчууд
Нандин ерөөлөө хайрламаар
Нааж чаддаг урчууд

Навчилж хатгамлаад хөрөглөмөөр ...”¹⁰ хэмээн холбон дуулдаг. Энд хуурч нарын иймэрхүү уламжлалт магтаалыг нүүлгэн хэрэглэсэн бус харин Ургамал хуурчийн өөртөө зохиосон өвчтэй гүнжийн магтаал болно.

Тус холбоонд хуурчаас гүнжид дурласан Чэн Яо Зиний дотоод сэтгэлийг урлаг сайхан илрүүлжээ. Гүнжийн өвчнийг засан сайжруулсан Чэн Яо Зинь гүнжтэй хуримлах хэмээн үдэд унтдаг хүн гүйж босоод үс гээгээ үнэхээр засжээ.

“Босго өндөр толийн урдаа
Бурзайн бурзайн зогсоод
Биеэ шинжээд үзчихсэн ээ хө
Эрээн халтар царайн дээр
Улаан цагааныг нь тааруулж байгаад
Ширтээд ширтээд хатчихсан
Эртийж гарсан соёо шүдийг
Нууж чадахгүй агсаар
Өөр үлдээсэн юм бүхнийг
Өнгөтэй болгоод авчихсан аа хө”

гэж Чэн Яо Зиний үйл ажиллагаагаар нь өнгөнд дуртай зан чанарыг нь дүрслэн зурагласан байна.

¹⁰ Чойжигаваа эмхэтгэв, (1997) “Монгол ардын уламжлалт холбоо” Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.,

Гурав. Ард иргэдэд туслан албаны ноёдыг дайсагнадаг зан чанар: Чэн Яо Зинь бол Сю Ян Ди хааны харгис бурангуй засаг төрийг эсэргүүцэж Эр Лүн Шань ууланд гарч журмын тугийг босгосон баатар эр мөн. Тиймээс тэр үгээгүй ядуу ард иргэдийг өрөвдөн туслан дэмжиж, эзэрхэг дээрэнгүй ноёд түшмэдийг дайсагнадаг зан чанартай болсон юм.

Чэн Яо Зинь хөлөг унаагаа хуяг дуулгаа хулгайчид автаад уулын хярд дааран дагжиж хөлдөх шахахдаа хүн алж хувцасыг нь булаан өмсдөг. Тэр хүн алсандаа *“аяа даарч үхсэнээс дээр гэж нэг хүн алчихлаа, за хүн гэнэ чи, сайн төрлийг ол, авгай нь зовлон дээр учирч, зовлонд даарсан Хүн ШИ Мо ван хо, замын ах дүү чи, дээлийг булаасан би мөн. Чи сайн төрлийг ол. Чи сайн төрлийг ол оо”* гэж түүний сайн төрлийг олохыг залбиран даатгаад *“тэр хүний толгой биеийг аваачиж нийлүүлээд, чулуугаар дарж ориуулж”* тавьдаг. Үүнээс Чэн Яо Зиньий хүн алж хувцас булаасан балмад хэрцгий нэг талыг үзэж гарахын хамт түүний залбиран даатгасан нинжин сэтгэлийг ч үзэж гарч болно. Чэн Яо Зинь Лю Зя Зуан-д ирээд өөрийгөө:

*“Алтан сүмбэр уулын
Нань Зи Сэ-ийн шавь аа
Ари хувилгаан бүрхнаас
Эрдэм сурсан оточ оо
Дөчин есдүгээр шавь нь
Зю Мин Сян Шэн гэдэг
Дэлхий дахинд буугаад би
Өглөг буян үйлдэв гэлээ
Өвчнийг чинь засаад эдгээчихвэл болно
Үзэж харсан хүчин зоос гэж авахгүй
Эмийн богцын эмээ
Баглаад өгвөл болчихно”*

гэж ухуулсан мөртөө Лю Бао Юн зэрэг ядуу зүдүүгийн туйл болсон ард иргэдийн өвчин эмгэгийг нь мөнгө зоос авахгүйгээр засаж өгдөг. Лю Минь, Сян Юй Минь гүнжийн өвчнийг засуулахаар залсанд Чэн Яо Зинь : *“огт болохгүй, төрийн үүдэнд түшмэлийг засахаар би гарч ирсэнгүй, түлээ модны ард тариалангийн ард түвэгдэж байгаа улсад тус хийнэ гэж гарч иржээ”* гэж үгээгүй ядуучуудын өвчин тахалыг нь арилган өглөг буян хийдгээс биш, төрийн түшмэдэд тус дэмжлэг болдоггүй гэх санааг тодорхой гаргажээ. Чэн Яо Зинь гүнжийн өвчнийг засан эдгэрүүлээд фүма суух хэмээн баярлаж байхдаа:

*“Үгэндээ хүрдэг Ян Линь Ван
Даавуу таарах ч таарчээ
Эрт өдрийн тэр жилээ
Мартаж ахуу даа, хулгайчийн зулзага
Хон Ту Лингийн хотол дээр
Хон Ма Лан байлдаад
Өрөөсөн шүдийг нь хуга цохиод
Өндөр дуулгын оройг нь могой цохьсон
Мэдэхгүй ахуу даа*

Томийн зулзага аа” гэж Ян Ди хааны авга Дэн Жоу Фүгийн Ян Линь ванг *“хулгайчын зулзага, Томийн зулзага”* хэмээн хараахын муугаар харааж, хорсон занаж байгаа сэтгэлгээгээ илтгэжээ. Дээрхээс үзэхэд Чэн Яо Зиний үгээгүй ядууг өрөвдөн

тэтгэх, өстөн дайсан ноёд түшмэдийг эсэргүйцэн дайсагнадаг зан чанарыг голдуу Чэн Яо Зиний үйл ажиллагаа ба үзэл сэтгэлгээгээр нь илрүүлэх арга барилаар илтгэсэн байна.

Дөрөв. Бүдүүлэгийн доторх нарийлаг зан чанар: Хуурчаас Чэн Яо Зинийг маш бүдүүлэг эр болгон зураглан дүрсэлсэн юм. Эр Лүн Шань ууланд гарч журмын тугийг босгож Хүнь Ши Муо ван болсон байтлаа архинаасаа өөр юмыг боддоггүй, архи ууж согтоод уулны хярд шалдан нүцгэн унтчихдаг бүдүүлэг эр, баатар жанжин. Чэн Яо Зинь архин Шао Гуо газар ирээд найман хул архи уусны дараа хулыг газар дээр хаясан байна. Лю Бао Юнгийн эхнэрийн судлыг барьсан учрыг (алсан малын гуяыг чангааж байх адил, шав хийтэл базайж атгатал, үү гэж дээшээ нэг эргэж, дотогшоо нэг татаж) хэмээн дүрсэлж байна. Ян Линь вангийн гүнжийн судлыг ч энэ мэт үзэж гүнжийг айлгасан юм. Эдгээр дүрслэлүүдээс Чэн Яо Зиний бохир бүдүүлэг зан чанарыг мэдэж болно. Хуурчаас Чэн Яо Зинийг хар бүдүүлэг хэмээн дүрсэлсэн төдийгүй бүдүүлэг доторх нарийлаг зан чанарыг ч зураглан гаргажээ. Жишээлбэл: Луо, Чэн Яо Зиний уулнаас бууж учрыг асуусанд

*“Арван орны хаан гээд
Ууланд суусан ван юм чинь
Албаны учраар гарна даа
Алсдаан хүнд л бүү хэл
Анх бид хоёр болно биш үү”*

гэж аргадан гуйж хэлжээ. Энэхүү охины гуйдлаас Чэн Яо Зиний нарийн ухаан нямбай санааг мэдэж болно. Чэн Яо Зинь өл хоолгүй өлсөж өлбөрөн явахдаа хоол будаа олж идэх арга ухаан бодож олсон учрыг *“Гэнэт бодохын үед инээд төрлөө, цэргийн Жюнь Ши Сю Мао гүн чинь бодож олохгүй, Чэн Яо Зинь би ганцаараа явбал олохоос биш, миний аргыг хэн мэднэ буй. Би эднийг гуйлгалж чадна”* хэмээн дүрсэлдэг. Энд Чэн Яо Зинь өөрийгөө сэцэн мэргэн, арга ухаантай хэмээн боддог юм байна. Чэн Яо Зинь, Лю Бао Юнгийн эхнэрт гурван өнгийн эмийг хольж уулгаад *“Энэ шөнө яахыг мэдэхгүй гэж ханзны баруун угаар сунж баруун тийш харж унтаад үхэх чимээ нь гарлаа гэвэл өвгөн урьдаар дутаачихвал дээр ээ..”* гэж *“унтсан маягаар овлоод”, “сэрүүнээр хамрыг хоржигнотол татсан”* үйл явдал ба Чэн Яо Зиний Ян Линь Ванд *“Албан ордонд ирэхгүй гэлээ, албаны хоёр түшмэл чинь гуйгаад байна, аргагүйдээ ирсэн. Ганц их вангийн амласан нэг үг байх дээр би одоо сая хүрч иржээ”* гэж Ван Лин Вангийн аман үгийг нь авч асуусан асуулт зэрэг нь бүр Чэн Яо Зиний нарийн ухаан нямбай санааг гаргаж байна. Гэтэл дархан хуурч Пажай Чэн Яо Зиний ухаан санааг ондоо нэг янзаар зураглажээ. Түүнийг *“Арав хүртэлх тоог тоолоход торчихно”* гэж дүрсэлжээ. Чэн Яо Зинь оюун ухаанаар дулимаг байдаг тул гурван хүнээс онцгой айдаг. Нэг нь Шиү Мао гүнгээс айна. Шиү Мао гүн бол ертөнцийн зүйг мэддэг, царайг үзэж зүсийг лавлавал мөн учрыг олж хэлэх болохоор айна. Нөгөө нь хамт сурагч байсан Цинь Шү Баогаас айна. Тэр эрдэм бичгийг сурч гэгээн тунгалаг болжээ. Гэтэл Яо Зинь нэг үсэг ч сурсангүй, ийм болохоор Цинь Шү Баогаас айна. Нөгөө нэг нь Луо Чэн гээс айна. Луо Чэн бол *“Төмөр мэт сэтгэлтэй”*. Тэгэхээрээ бол айна гэжээ. Тиймээс Лаозар хуурчийн босгосон Чэн Яо Зиний дүр нь Пажай хуурчийн амилуулсан дүрээс нарийн ялгаатай болжээ.

Тав: Чэн Яо Зиний төрсөн төлөв шинжийн дүрслэл: Чэн Яо Зиний төрсөн байдлыг дархан хуурч Пажай:

“Үүл өөргүй хөх царайтай, үзэх нүд нь дөрвөлжин, өндөг дунд нь шигтгэж, одоо өөргүй гэрэлтэй, хөмсөг доороо залгаад, дотроо гэрэлтэж, гурав сүүлдэж, дээшээ сарвайсан чих мөрөнд тулсан, хамар хөндлөн хацраа тулж, хоёр самсаа нь чихний ойрхонд хүрсэн, хооронд нь байх нүхэнд нь хэрээ шаазгай хэдэн сараар үүрлэвч мэдэхгүй юм аа, хэд хоноод нийлэхлээр өндгөө хагалаад зулзага нь нисмээр болчихсон ийм хамартай, сүртэй төрсөн хүн юм шүү. Ам ярвайгаад давхар ургасан дөрвөн соёо нь дээш доош тэлсэн, дээд уруул дөрвөн хуруу, доод уруул дөрвөн хуруу, дийлэнхдээ найман хуруу, дотроос ургасан дөрвөн соёо болохлоор хоёр уруул нь хоноод уулзахгүй, хоол идэхээр бас уулзахгүй, хоорондуур нь хий татаад тээглэдэг юм”¹¹ гэж царай нүүр, нүд хөмсөг, хамар ам, шүд уруул, чих зэргийг давууллын аргаар дүрслэн зурагласан байна. Луузар хуурч энэхүү уламжлалыг залгамжлан авч “Эрлэгийн Фань Гуон (Эрлэг номун хаан) ирсэн адил, дөрвөн соёо гадагшаа сэрийгээд, тэр тогсог шүд зүг зүгтээ бутраад тэр сахал үс сэрийгээд” хэмээн зохиолын хүний нүдээр Чэн Яао Зиний төлөв шинжийг зураглажээ. Түүний энэхүү дүрс байдлыг бас:

“Гахайн дөрвөн соёо нь
Гадагшаа дотогшоо сэрийгээд
Гал улаан сахал нь
Зүг зүгтээ бутраад
Гарааны хоёр нүд нь гэдэг
Ухархайдаа гүрвэлзээд”

гэж хажуу талаас нь дүрслэх аргаар шүд соёо, сахал хууз, нүд зэргийг маш амьдлаг дүрсэлжээ.

Чэн Яао Зиний царайн өнгийг Пажай Хуурч хөх өнгөтэй гэсэн бол Лаозар хуурч хар өнгөтэй хэмээн дүрсэлжээ. Жишээлбэл: Чэн Яо Зинийг хар тэргэнд хорьж хүлээд, нийслэл хотод хүргэх учрыг “Үхсэн алттай амьд алттай, шар алттай хар алттай бүгдийг нь аваад явна” гэж Лу Минь, Сян Юй Минь хэлсэн байна. Үүнээс үзэхэд Чэн Яо Зинь бол бараан хар зүстэй юм байна.

Хуурч гуай Чэн Яао Зиний царай зүсийг дээрх мэт дүрсэлснээр барахгүй түүний гэдэс гүзээний ихийг дүрслэн үзүүлсэн юм. Чэн Яо Зинь өлсөөд шингэн будаа идсэн байдлыг “Чэн Яо Зинь дараагаар нь арваад аяга хөнтөрчээ хө. Энэ идэх гэдэг чинь үнэхээр аймаар, эмч хүн гэдэг чинь болбол, эмзэгхэн бага л сага л идээд болдог, энэ эмч мамагийн идэж байх гэдэг чинь өвс түлээний улсууд авч өгч байх адил авч өгч байна. Аяа, хоёр аягаар зөөгөөд завдахгүй” гэж дүрслэв. Гүнжийн биед наалдаж байх юмыг арилгах хэмээгээд “Арван жин үхрийн мах, арван таван жин архи” авчруулан ууж идэхээр бэлтгэжээ. Эдгээрээс үзэхэд Чэн Яао Зиний ходоод гэдэс гэдэг хүн айлгамаар их байна.

Дээрх задлалтаас доорх дүгнэлтийг гаргаж болно.

1. Цустай махтай, сайнтай саартай Чэн Яао Зиний уран дүрийг амилуулан босгожээ. Чэн Яо Зинь бол архи гэвэл амь авахгүй дуртай, өнгө гэвэл үзүүргүй бахтай, ард иргэдийг туслан дэмжиж, албаны ноёдыг эсэргүүцэн тэмцдэг. Тэр бол өнгө зүс хар, үзэх нүд нь ухархайдаа гүрвэлзэж, гахайн дөрвөн соёо гадагшаа дотогшоо сэрийж, гал улаан сахал нь зүг зүгт бударч, идэх гэмээр гэдэс гүзээтэй аймаар төрсөн баатар эр. Тэр хэдийгээр бохир бүдүүлэг зан чанартай боловч заримдаа бас нарийн санаа нарийлаг ухаантай. Өөрөөр хэлбэл, бүдүүлгийн дотор нарийнтай хүн юм.

¹¹ Цогт, Чэн Ган Лүн (2002) “Пажайн судлал” Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.,

2. Хуурч Лаозар бол Пажай зэрэг ахмад үеийн хуурчийн урлан бүтээсэн Чэн Яао Зиний дүрийг уламжлан авч урагшаа хөгжүүлжээ. Лаозар хуурчийн урлан амилуулсан Чэн Яао Зиний дүрээс Пажай хуурчийн бүтээсэн Чэн Яао Зиний дүрийн онцлогийг олж харахын хамт Лаозар гуайн зохиосон Чэн Яао Зиний дүрийн шинэ шинэ онцлог шинж, зан чанарыг ч олж харна. Энэхүү шинэ зүйл бол даруй Лаозар хуурчийн Чэн Яао Зиний дүрийг бүтээхэд үзүүлсэн гавьяа зүтгэл болно. Лаозар гуай, Пажай, Дорж зэрэг ахмад үеийн хуурчаас хянамгай суралцан, тэдний уран бүтээлийг залгамжлан, уран дүрийг уламжлахын хамт, өөрийн оюун тархиа шавхан Чэн Яао Зиний уран дүрийг улам нэг шинэ хэлбэрт хүртэл хөгжүүлжээ.

3. Лаозар хуурчийн урлан бүтээж амилуулан босгосон Чэн Яао Зиний уран дүрд Хятад үндэстний “*Тан улсын үлгэр*”, “*Сян Ма Зуаний үлгэр*” дэхь Чэн Яао Зиний дүрийн зан чанарч уусан нийлэлдэж байх юм. Учир нь Пажэй, Дорж зэрэг ахмад нэг үеийн хуурч нар, хятад үндэстний Бэнсний үлгэрээс эх авч тус үлгэрийг хэлж Чэн Яао Зиний уран дүрийг амжилттай бүтээжээ. Гэвч хуурч нар Хятад үлгэрийг бүр мөсөн мөрдсөнгүй. Харин Хятад үлгэрийн ор мөр дээр шинэ нэг Чэн Яао Зиний дүр, Монголжуу Чэн Яао Зиний дүрийг урлан бүтээв. Тиймээс Лаозар гуайн амилуулсан Чэн Яао Зиний дүрд Хятад уран зохиол дахь Чэн Яао Зиний зан чанар, ахмад хуурчийн бүтээсэн Чэн Яао Зиний зан чанар ба Лаозарын өөртөө сийлбэрлэсэн Чэн Яао Зиний зан чанар бүр уусалцан нэгдэж байдаг.

4. Онолоор үйлдлэгээ жолоодуулж, онол үйлдлийг уялдуулан Чэн Яао Зиний дүрийг бүтээжээ. Лаозар гуай бол оюутан хуурч, онолтой хуурч, тэр өвөр монголын үндэстний багшийн дээд сургуульд суралцсан цагаасаа эхлэн утга урлагийн онол мэдлэгийг хичээн суралцсан бөгөөд удаа дараалан өгүүлэл зохиол нийтэлж хуурын үлгэр, холбоо шүлгийн тухай өөрийн үзэлдээ өгүүлэн ярьжээ. Лаозар хуурчийн өгүүлэл зохиолыг уншаад дахин түүний үлгэрийг сонсвол, тэр үлгэрээ хэрхэн онолоор жолоодуулж, онол ба үйлдлийг хэрхэн уялдуулж байсныг мэдэж болно. Чэн Яо Зинь гэх уран дүрийг ч онолоор жолоодуулан бүтээсэн нь илхэн. Энэ бол онолтой хуурчийн бусад хуурчаас онцлогтсон тал болно.

Дагалдуулал

Лаозар хуурчийн хэлсэн “Чэн Яо Зинь эмчилсэн нь” гэдэг үлгэрийн товч

Сүй улсын харанхуй төрийн үед, Шандуны сайн эрчүүд журмын тугийг босгон Эр Лүн Шан, Ва Ган Зай-д цуглараад Чэн Яо Зинийг их Ван Еэ гэж, Цинь Чюнь Юан Шуай хэмээн Сюй Мао Гүнг Жюнь Ши гэж эргээд бүгдээр хорин найман Тянь Ган одон бүрдээд байсан цаг юм.

Чэн Яо Зинь архинд дуртай тул өдөр бүр архи дарс ууж найрлан цэнгэж суутал Жюнь Ши Сюй, Мао гүн ирж Чэн Яао Зиний архи уухыг өдөр тогтоон зогсоолоо. Чэн Яо Зинь архи олж уухгүй болсон минь хамгийн их зовлон болжээ хэмээн бодож, уулын Ван суухгүй, өөрийн нутаг Бань жао Дяньдаа хариад архиа ууж сууя гэж сэтгэл шулуудаж хүлэг мориндоо морджээ. Чэн Яо Зинь нэг шөнө яваад дараа өдрийх нь гол үдийн үед нэг их айлд хүрч, архи нэрдэг нэрмэлийн газар нь буугаад халуун архийг долоо найман хул согттол ууж, мориндоо мордон үргэлжлэн замнав. Тэр яван явсаар нэг уулын хяр дахь сагсгар модны доор тулж ирээд морио уяж, хуяг дуулгаан тайлж модон сүүдэрт хоржигнотол унтаж орхижээ. Энэ үед Шандуны нэг наадамчин аль байснаа шүүгдээд амьдрахын аргагүй болохдоо Шан Си-д очиж баяжиж сууна хэмээн

зам хөөж байгаад Чэн Яао Зиний морийг олж үзэв. Энэ наадамчин модны доор ирээд Чэн Яао Зиний хуяг дуулга ба хүлэг морийг аваачиж худалдаж зарахыг бодон хуяг дуулгыг авч морийг ташуурдан мордон хөдөллөө. Гэтэл тэр морь өөрийн бэлчээр Эр Лүн Шан зүгээ довтлон явахаас биш, тэр наадамчны санаагаар явсангүй. Удалгүй Эр Лүн Шандаа буцан ирсэнд олон бүгдээр Хүн Шан Муо ван харьж иржээ хэмээн морийг тосон аваад хуяг дуулгыг хураамжилж наадамчныг хорьж тавив.

Чэн Яо Зинь шөнийн сэрүүнд дааран сэрээд хүлэг морь ба хүнд дуулгаа үзэхэд бүр байсангүй. Даараад тэсэхгүйдээ уулын ар хяраас уулын өмнө энгэрээр явж байтал харанхуй дотор нэг хүн ирэх таарчээ. Тэр түүнийг алаад (*барьж аваад*) хувцсыг нь шалдлан авч өмсөөд эмийг хэдэн уут үлдээгээд мөрөн дээрээ мөрөвчлөн гүйгээрээ уулнаас буулаа. Үд болтол яваад нэг их айлд хүрч өлөн гэдсээ дүүргэхийн төлөө өөрийгөө эмч гэж өвчин засна гэж бархирав. Энэ үгийг Лю Бао Юн гэдэг ядуу ард сонсоод өөрийн эхнэрийнхээ өвчнийг засуулах хэмээн гэртээ залаж авчрав. Чэн Яо Зинь Лю Бао Юнийн эхнэрд эм өгч уулгасанд өвчин нь эдгэрч эрүүл саруул болжээ. Лю Бао Юн баярлахдаа айл аймагтаа хувилгаан эмч иржээ гэж ухуулав. Түүнээс аваад Чэн Яо Зинийг залж өвчин үзүүлэх хүн тасрахгүй болж хувилгаан эмчийн нэр алдар хол ойр алдаршлаа. Энэ Жи Сэ-ийн дөчин есдүгээр шавь Жю Мин Шян Шен Лю Жя Да Зуан-д ирээд өвчин засаж буян үйлдэж байна гэдэг чимээг Дэн Жоу Фү-гийн хааны авга Лао Ху Ян Линь олж сонсчээ. Тэр өөрийн гүнжийнхээ өвчнийг үзүүлэхийн төлөө доорхи ард Лу Минь, Сян Юй Минь хоёрыг зарж Лю Жя Да Зуан-д хувилгаан эмчийг залахаар явуулжээ. Чэн Яо Зинь Дэнжоу-д ирсэн хоёрт “*очихгүй*” гэж урилгыг огоорсонд “*Хэрвээ гүнжийн өвчнийг эдгэрүүлбэл гүнжээ чамд өгөх гэнэ*” гэж хэлээд Чэн Яо Зинийг Дэнжоу-д урин авчрав. Жю Мин Сян Шэн Гүнжийн суудлыг барьж гүнжийн бие дээр муу юм наалдаж гэж өвчнийг нь тодолжээ. Тэр шөнө Чэн Яо Зинь гүнжийн биеэнд наалдсан юмыг арилгахын төлөө гүнжийн өргөөний гадар талын жижиг өргөөнд сахин суув. Шөнийн гуравдугаар жингийн үед гүнжийг хорлож байсан муу хорын амьтан ирснийг мэдээд Чэн Яо Зинь сүх өргөн нээсээр байж нуурын усанд оруулав. Олон бүгдээр шохой тээж авчраад нуурын усанд хаясанд, ус буцалахыг дагалдан чадлыг олсон удаан жилийн ван ба үхдэл болон гарч ирсэн ч тос цутган шатааж арилгажээ. Гүнжийн өвчнийг эдгэрүүлсэн тул түүнийг Чэн Яо Зинь-д өгөх хуримын учирт бүгдээр яаран Чэн Яо Зинь ч биеэ засаж хуримлахаар бэлтгэнэ. Гэтэл Лао Ху Ян Линь Чэн Яо Зинийг нэгэнт үзэж таниад дараа өдрийнх нь хуримлах ёслолын үед барьж хүлэхээр арга хэлэлцэн тогтов. Хэлэлцсэн ёсоор Чэн Яо Зинийг барьж модон тэргэнд хориод хаанд хүргэх Хуан ган мөнгөний хамт Чан Ань газар хүргэхээр мордон гарчээ.

Цэргийн Жюньши Сюй Мао гүн бичиг цэргийн олныг цуглуулж, улсын эзэн Чэн Яо Зинийг алдаж явуулсан учрыг шүүмжлэн хэлэлцэж, Луо Чэн-г эрэхээр яв хэмээн зарлигджээ. Луо Чэн зарлигийг хүлээн хуяг зэвсэг аль байснаа аваад хүлэг мориндоо мордон Чэн Яо Зиний төрсөн нутгийг чиглэн нэг өдөр Шан Шу Лингийн даваан дээр хүрч ирэв. Тэр давааны дээрээс ажиглан үзэхэд нэгэн салаа цэрэг морь шугуйн замаар бүрэг бараг өнгөрөх харагдсанд тосон очиж учрыг олохыг бодож морь довтолгон зэвсэг эргэн хүрч ирсэнд Ян линь Вангийн хоёр гочог Лу Минь, Сян Юй Миний цэрэг байсан аж. Луо Чэн тэд хоёулыг байлдан дийлээд үлдсэн цэргийг нь оруулж аваад Чэн Яо Зинийг авран гаргаж, Хуан Ган мөнгийг аваад Эр Лүн Шан уулын зүгээ мордлоо. Эр Лүн Шаны ах дүү олноороо Чэн Яо Зинь, Луо Чэн ээ тосон аваад баярын хурим тавьж баярлан жарган суув.

SUMMARY

In this paper, the character of Cheng Yao Jin in the fairy story 'Cheng Yao Jin heals' by storyteller Lao Si Er is analyzed thoroughly from five aspects. In analyzing process, Chinese traditional stories and social state, people's life and thinking at the time the story was written are taken into account. In the end, it is proved that although the story and its main character Cheng Yao Jin is originated from Chinese story, it has become the Mongolian story and character that is now completely adapted to Mongolian culture.